



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/160

Мөрөн сум

Авто тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын үзлэгийг сумдад зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7.1.1, 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг зохион байгуулсугай.

2.2024 оны авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, сумдад тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг тооллого явуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Сум, багт байгаа автомашин, чиргүүл, трактор өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн бүртгэл судалгааг гаргах, техникийн үзлэгт тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах зэрэг ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын салбар комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Авто тээврийн хэрэгслийн явуулын техникийн хяналтын үзлэгийн үеэр Autobox апплейкшинийг иргэдэд сурталчилж гар утсанд нь суулгах, тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ олгох, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, онлайн тасалбар захиалга, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, тээврийн хэрэгслийн өмчлөгчийн лавлагаа, мэргэшсэн жолоочийн шалгалт өгөх зэрэг үйлчилгээг цахимаар авах боломжтой талаар иргэдэд мэдээлэл, зөвлөмж өгөх, ашиглахаа больсон боловч улсын бүртгэлийн санд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Ө.Баттулга)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА


П.ЛХАГВАЖАВ



6712010477



Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 08 - ны өдрийн  
А/160 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



Ажлын хэсгийн ахлагч:

М Хуягбаатар - (Аймгийн засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Оюунтуяа - (Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга)

Ө.Баттулга - (Аймгийн Автотээврийн төвийн дарга)

А.Алтанцоож – (Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Ч.Хуншагай - (Аймгийн Татварын хэлтсийн дарга)

Х.Тайванбаяр - (Мөрөн сумын Засаг дарга)

Б.Батбаатар – (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн  
ахмад)

Нарийн бичгийн дарга:

Х.Бямбадорж- (Аймгийн Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер)



Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 08 - ны өдрийн  
А/160 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

СУМДАД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ  
ТООЛЛОГО ЯВУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Нэгдүгээр чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Тосонцэнгэл	Автотээврийн төвийн ажлын хэсэг	4/15-17	450	3 хоног
2	Рашаант		4/18-20	500	3 хоног
3	Их-Уул		4/21-23	480	3 хоног
4	Тариалан		4/24-27	800	4 хоног
5	Эрдэнэбулган		4/28-30	380	3 хоног
нийт				2,610	16 хоног
Д/д	Хоёрдугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Төмөрбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг	5/3-4	370	2 хоног
2	Шинэ -Идэр		5/5-6	280	2 хоног
3	Галт		5/7-9	500	3 хоног
4	Жаргалант		5/10-12	670	3 хоног
нийт				1,820	10 хоног
Д/д	Гуравдугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Могойн гол	Автотээврийн төвийн ажлын хэсэг	5/15	680	1 хоног
2	Цэцэрлэг		5/16-17		2 хоног
3	Цагаан -Уул		5/18-20	930	3 хоног
4	Бүрэн хаан		5/21	630	1 хоног
5	Бүрэнтогтох		5/22-23		2 хоног
нийт				2,240	9 хоног
Д/д	Дөрөвдүгээр чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Арбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг	5/27-28	550	2 хоног
2	Алаг-Эрдэнэ		5/29-30	450	2 хоног
3	Хатгал		5/31-6/1-2	450	3 хоног
4	Ханх		6/4-5	150	2 хоног
				1,600	9 хоног
Д/д	Тавдугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Баянзүрх	Автотээврийн төвийн ажлын хэсэг	6/7-8	280	2 хоног
2	Улаан-Уул		6/9-10	400	2 хоног
3	Ренчинлхүмбэ		6/11-12	370	2 хоног
4	Цагааннуур		6/13-14	140	2 хоног
нийт				1,190	8 хоног
Д/д	Зургаадугаар чиглэл	Хариуцах эзэн	хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Цагаан-Үүр	Автотээврийн төвийн ажлын хэсэг	6/17-18	190	2 хоног
2	Чандмань-Өндөр		6/19-20	290	2 хоног
3	Түнэл		6/21-23	410	3 хоног
нийт				890	7 хоног